

БАТЛАВ
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Х.ЭРДЭНЭБИЛЭГ

2018 оны сарынөдөр

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

2018 оны 11-р сарын 16 өдөр

Улаанбаатар хот

1. Зорилго

Нийтлэг үйлчилгээний газрын зоогийн газар, цайны газруудын эрүүл ахуй, хоол үйлдвэрлэл, түүний хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны хэвийн ажиллагааг хангах, зөрчил дутагдал, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

2. Хамрах хүрээ

Нийслэлийн засаг захиргааны 1, 2, 5-р байруудад байрлах зоогийн газар, цайны газрууд

3. Хугацаа

Ажлын хэсэг хяналт-шинжилгээг 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 23-ны өдрийг дуустал

4. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Гишүүд: Байр ашиглалтын албан дарга Г.Батзаяа

Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан Т.Итгэл

Их эмч Н.Энхзаяа

5. Хяналт-шинжилгээ хийх чиглэл

5.1 Хяналтын хуудасны асуултуудын хүрээнд хяналт-шинжилгээ хийх;

5.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа, түүний мөрдөлтөнд хяналт тавих;

5.3 Шаардлагатай гэж үзсэн бусад ажил;

6. Бусад

6.1 Ажлын хэсэг хяналт-шинжилгээ хийхдээ холбогдох баримт бичгийг судлах, асуулга явуулах зэрэг дүн шинжилгээний түгээмэл аргуудыг хэрэглэнэ.

6.2 Хяналтын хуудас нь энэхүү удирдамжийн салшгүй хэсэг байна.

6.3 Ажлын хэсгийн гишүүд хариуцсан чиглэл тус бүрээр хяналт-шинжилгээ хийж, аливаа дутагдал, түүний шалтгаан нөхцөл, арилгах арга замын тухай саналыг боловсруулж, газрын даргад танилцуулна.

---o0o---

ЗООГИЙН ГАЗАР, ЦАЙНЫ ГАЗРУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ
ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ХЭСГИЙН

ИЛТГЭХ ХУУДАС

2018 оны 11 дүгээр сарын 27

Улаанбаатар хот

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын даргын баталсан удирдамжийн дагуу зоогийн газар, цайны газруудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх ажлын хэсэгт Байр ашиглалтын албаны дарга Г.Батзаяа, их эмч Н.Энхзаяа, дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан Т.Итгэл нар ажилласан ба 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрөөс 11 дүгээр сарын 23-ны өдрүүдэд хяналт шинжилгээг хийлээ.

Ажлын хэсэг тус газрын даргын 2018 оны А/44 дүгээр тушаалаар батлагдсан “Бодлогын болон захирамжлалын баримт бичгийн хэрэгжилт, Нийтлэг үйлчилгээний газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх журам”-ыг удирдлага болгон ажиллалаа.

Хяналт-шинжилгээний үр дүн:

Гал тогооны халуун цехийн тоног төхөөрөмжийн ажиллагаа хэвийн, цэвэрлэгээ үйлчилгээ тогтмол, өдөр тутмын хоолны дээж авалт, бичилт тогтмол хийгдэж байлаа. Гэсэн хэдий ч:

- Зарим газруудын халуун цехийн өрөөний сантехникийн шугам хоолойд засвар үйлчилгээ хийх, ил байгаа бохирын шугам, хоолойг битүүмжлэх;
- Тамгын цайны газрын цахилгааны шит, кабелийн аюулгүй ажиллагааг хангах;
- Мах махан бүтээгдэхүүний ангилал, хаягжуулалтыг сайжруулах;
- Заалны гэрлийн бүрэн бүтэн байдлыг хангах;
- Ариутгалын бодисын хэрэглээг сайжруулах, найруулсан бодисыг хаягжуулах

зэрэг шаардлагатай зарим дутагдлыг засах хугацаатай үүргийг хариуцсан албан хаагчдад өгч зарим зөрчлийг газар дээр нь арилгуулан ажиллаа.

Дүгнэлт:

Дээрхи алдаа дутагдлыг хэрхэн засч, залруулах талаар заавар зөвлөгөөг өгч, бүртгэл хөтлөлтийн маягтуудыг өөрсдийн үйл ажиллагаанд нийцүүлэн хөтөлж хэвшүүлэхийг зөвлөв. Мөн дээжний савыг нэмж авсан, амтлагчийн савуудыг шинэчлэн шилэн тагтай саваар сольж хаягжуулан жигдрүүлсэн. Хүнсний бүтээгдэхүүн хадгалах хөлдөөгч, хөргөгчийг дугаарлан хаягжуулж, температур хэмжигчээр заалтыг тогтмол хянаж бүртгэл хөтлөлт хийж байна.

Цаашид анхаарах асуудлууд:

- Мэргэжлийн байгууллагаас сургалт авах
- Зоогийн газарт мөрдөгдөх хүнсний бүтээгдэхүүний ул мөрийг тогтоох бүртгэл хөтлөлтийг сайжруулах

- Ариутгалыг тогтмол хийж тэмдэглэл хөтлөх

ТАНИЛЦСАН:

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ЭРДЭНЭБИЛЭГ

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:

БАЙР АШИГЛАЛТЫН АЛБАНЫ ДАРГА

Г.БАТЗАЯА

ИХ ЭМЧ

Н.ЭНХЗАЯА

ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН

Т.ИТГЭЛ